Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 тоот тушаалын
6 дугаар хавсралт

Хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн, Бадамдорж Баасансүрэн

2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭС-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1.1. Салбарын бодлого, хөтөлбөр, стратегийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг төлөвлөх, санхүү, хөрөнгийн удирдлага, зохицуулалт, төсөв, санхүүгийн мэдээллээр хангах, шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх, батлагдсан хөрөнгө оруулалтын болон урсгал зардлыг санхүүжүүлэх, гүйцэтгэлийг хянах, үр дүнг тайлагнах; | | | | | | | |
| 1 | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүдийг мэдээллийг тухай бүр www.shiilendans.gov.mn сайтад байршуулах. /100 хувь/ | Шилэн дансны мэдээллийг хугацаанд оруулсан байх, хувиар | - | Тайланг тухай бүр хугацаанд www.shiilendans.gov.mn сайтад байршуулна./ 100 хувь/ | Шилэн дансны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх хэсэгт "мэдээллийг тогтмол шинэчилж байх, өөрчлөлт орсон тухай бүр өмнөх мэдээллийг цахим хуудасны архивт хадгалах, архивын мэдээллийн санд нэвтрэх, татаж авах, хэвлэх боломжтой байх.", 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.2 дахь хэсгүүдэд заасны дагуу сар, улирлын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор, хөрөнгө оруулалтын зарлага, санхүүжилтийг | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | төсөл, обьект тус бүрээр тайлагнан, www.shiilendans.gov.mn сайтад байршуулан ажилласан. | | |
| 2 | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр болон шилжин хэрэгжих төслийн ТЭЗҮ, зураг төсвийн гүйцэтгэлийн санхүүжилтийг тухай бүрд нь хянан, санхүүжилтийг шуурхай олгох арга хэмжээ авах | Тухай бүр, гүйцэтгэлээр | - | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр болон шилжин хэрэгжих төслийн ТЭЗҮ, зураг төсвийн гүйцэтгэлийн санхүүжилтийг тухай бүрд нь хянан, санхүүжилтийг шуурхай олгох арга хэмжээ авна. | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр болон шилжин хэрэгжих хөрөнгө оруулалтын төслүүдийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг авч ажилласан. 1. Төсөл, арга хэмжээний гүйцэтгэлүүдийг тухайн бүр хянан баталгаажуулж, холбогдох санхүүгийн баримтуудыг бүрдүүлэн санхүүжилтийн эрх нээлгэхээр цахим болон цаасан хэлбэрээр сангийн яаманд хүргүүлэн ажилласан. 2. Хэрэгжиж дууссан төсөл хөтөлбөрүүдийн гэрээнүүдийг гүйцэтгэлийг баталгааг, гүйцэтгэгч компанийн ирүүлсэн хүсэлтэд үндэслэн, тухай бүр чөлөөлүүлсэн. 3. Төрийн өмчийн бодлогын зохицуулалтын газрын 366 дугаар тогтоолоор нийт 15 байгууллагын, улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж дууссан 54 зураг, төсвийг ашиглагч байгууллагад хүлээлгэн | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | өгч, санхүүгийн холбогдох бүртгэлийг хийлгэхээр даалгасан бөгөөд 10 ашиглагч байгууллагад зураг төслүүдийг захиалагчийн техникийн хяналт хэрэгжүүлэгч байгууллагаас хүлээлгэн өгч, тэдгээрийн өмчлөл бүрэн шилжүүлэн ажилласан. Түүнчлэн дахин 12 төслийн 5.6 төгрөгийг өртөг бүхий хэрэгжиж дуссан зураг төслийг ашиглагчийн өмчлөлд шилжүүлэхээр ТӨБЗГ-т хандсаны дагуу зураг төслийг өмчлөх хүсэлтийг ирүүлэхээр бүх ашиглагчтай холбогдсон. 4. 2023, 2024 онд хэрэгжиж эхэлсэн бөгөөд ТЭЗҮ зураг төслүүдийн захиалагчийн техникийн хяналтын зардлыг суутгасан боловч хяналтын гэрээгүй төслүүдийн хяналтын гэрээг нөхөн хийж, захиалагчийн хяналтын тайлангуудыг хяналт хэрэгжүүлэгчээс мөн нөхөн авч захиалагчийн техникийн хяналтын дансийг суллах арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна. 5.Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж, гэрээт ажлын | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хүлээлгэн өгсөн зөвлөх үйлчилгээний компаниудын тухай бүрийн хүсэлтийн дагуу, гэрээт ажлын талаарх тодорхойлолтын тухай бүр гаргаж, хүргүүлсэн. | | |
| 3 | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр болон шилжин хэрэгжих төслийн ТЭЗҮ, зураг төсвийн гүйцэтгэлийн санхүүжилтийн тайланг боловсруулах. | Тухай бүр, гүйцэтгэлээр | - | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр болон шилжин хэрэгжих төслийн ТЭЗҮ, зураг төсвийн гүйцэтгэлийн санхүүжилтийн тайланг боловсруулна. | 2025 онд Хөрөнгө оруулалтын нийт 146.4 тэрбум төгрөг төсөвлөгдсөн бөгөөд дараах байдлаар гүйцэтгэлүүдийг санхүүжүүлэн ажилласан. 1.Хөрөнгө оруулалтын 107.1 тэрбум төгрөг буюу 73 хувийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн 2 төсөл эзэлж буй бөгөөд "Концесс эзэмшигч "Макс-роуд" ХХК-ийн хэрэгжүүлсэн "Баянхонгор-Алтай чиглэлийн 126.7 км зам"-ын төслийн 10.9 тэрбум төгрөгийг холбогдох шийдвэрийг дагуу шилжүүлсэн. Харин сүүлийн "Монгол ЛЗ зам гүүр" ХХК-ийн хэрэгжүүлж буй "Дархан-Сэлэнгийн авто замаас Шаамар-Зүүнбүрэн-Цагааннуур-Зэлтэрийн боомт чиглэлийн 120.85 км зам"-ийн төслийн 96.2 тэрбум төгрөг үлдсэн. 2. ЗГХХГ-ийн байрны их засварын ажилд 2.3 тэрбум төгрөг | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | төсөвлөгдсөн бөгөөд одоогийн байдлаар 0.7 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй байгаа бөгөөд төсвийн жилд үлдэх санхүүжилтийг олгохоор тооцоолсон. 3. Шинжлэх ухааны барилгын хувьд 21.4 тэрбум төгрөг төсөвлөгдсөнөөс 18 тэрбумын гүйцэтгэлийг санхүүжүүлсэн ба үлдэх 3.4 тэрбум төгрөгийг төсвийн жил бүрэн санхүүжүүлэх боломжтой гэж тооцоолсон. 4. ШУА-ийн хүрээлэнгийн тоног төхөөрөмжийн хувьд 7.9 тэрбум төгрөг 2 багцад хуваагдан төсөвлөгдсөн бөгөөд эхний багцын 3 тэрбум төгрөгийг санхүүжүүлж, лабораторийн тоног төхөөрөмжийг бүрэн хүлээн авсан бол үлдсэн багцын тоног төхөөрөмжийг 12 сарын 15-ны дотор хүлээн авч санхүүжигдэхээр хүлээгдэж байна. 5. ТЭЗҮ-ийн хувьд 7.7 тэрбум төгрөг төсөвлөгдсөнөөс 1 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй байгаа бөгөөд төсвийн жилд багтаан 2025 онд хэрэгжиж буй нийт 19 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | төслөөс 11 төслийг бүрэн дуусгаж 3 тэрбум төгрөгийн гүйцэтгэлийн санхүүжүүлэх боломжтой гэж урьдчилсан байдлаар тооцоолсон бөгөөд үлдэх 8 төслийн 3.7 тэрбум төгрөг барьцаа дансанд үлдэнэ. Түүнчлэн 2025 онд Барьцаа хөрөнгийн дансанд байрших Концессын 6 төслөөс 3 төслийг, ТЭЗҮ 2023 оны 39 төслөөс 37 төсөл хөтөлбөрийг, ТЭЗҮ 2024 оны 61 төсөл хөтөлбөр 39 төсөл хөтөлбөрийг бүрэн санхүүжүүлж, барьцаа данснаас суллан, гүйцэтгэлийг баталгаажуулан ажилласан. Хавсралт: 1 файл | | |
| 4 | Яамны эрх бүхий албан тушаалтны гарын үсгээр баталгаажих шийдвэр, албан бичгийн төслүүдийн тухай бүр боловсруулан, удирдлагаар баталгаажуулах. | Тухай бүр, гүйцэтгэлээр | - | Яамны эрх бүхий албан тушаалтны гарын үсгээр баталгаажих шийдвэр, албан бичгийн төслүүдийн тухай бүр боловсруулан, удирдлагаар баталгаажуулна. | 1. Боловсруулж, баталгаажуулсан тушаалууд: 1.1. "Эдийн засаг, хөгжлийн яамны албан хаагчдад орон сууцны дэмжлэг үзүүлэх тухай журам"-ын төслийг хуулийн хэлтсийн бүрэлдэхүүнээр боловсруулан, нийт албан хаагчдаас нээлттэй санал авахаар байгууллагын цахим хуудсанд байршуулсан. 1.2. Эдийн | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | засаг, хөгжлийн яамны болон Засгийн газрын холбогдох шагналд материал ирүүлсэн албан хаагчдаас шаардлага хангасан албан хаагчдыг шагнахаар Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оны А/23 дугаар "Шагнах тухай" тушаалын төслийг боловсруулан, баталгаажуулсан. 1.3. Төрийн нарийн бичгийн даргын "үнэлгээний хороо байгуулах тухай" 2025 оны А/117 дугаар тушаалын төслийг боловсруулан, баталгаажуулж "Худалдааны хуулийн төсөл /анхдагч хууль/-ийн олон нийтийн хэлэлцүүлэг" зохион байгуулах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг байгуулсан. 2. Эдийн засаг, хөгжлийн яамны салбарын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, эрдэм шинжилгээ, сургалт, судалгааны чиглэлээр хамтран ажиллах зорилгоор Монголын Хуульчдын холбоотой 2025.04.09-ны өдөр "Хамтын ажиллагааны санамж бичиг"-ийн төслийг боловсруулан, | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | баталгаажуулсан. Хамтын ажиллагааны санамж бичигт Эдийн засаг, хөгжлийн яамыг төлөөлж Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү гарын үсэг зурсан. 3. Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах асуудлуудын талаарх мэдээлэл, эдийн засгийн нөхцөл байдлыг олон нийтэд шуурхай түгээх, мэдээллээр хангах зорилгоор яамны байрны холбогдох хэсэгт шаардлагатай засвар хийх, тавилга, хэрэгсэл авахтай холбогдох Төрийн нарийн бичгийн даргын тушаалын төсөл болон хологдох гэрээний төслийг боловсруулан, удирдлагуудаар баталгаажуулан, хэрэгжилтийг бүрэн хангаж ажилласан. 4. "Гадагшаа чиглэсэн" 88 албан бичиг, "дотогшоо чиглэсэн" 28 дотоод бичигт санал, хариу хүргүүлэх тухай албан бичгийн төслийг боловсруулж, баталгаажуулсан. | | |
| 5 | Улсын төсвийн хөрөнгө | Тухай бүр | - | Улсын төсвийн хөрөнгө | Монгол Улсын Засгийн | 1-р сар, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | оруулалтаар шинээр болон шилжин хэрэгжих төслийн ТЭЗҮ, зураг төсвийн гүйцэтгэлийн санхүүжилтийн мэдээллийг гаргаж сар бүр Сангийн яаманд хүргүүлэх. | | | оруулалтаар шинээр болон шилжин хэрэгжих төслийн ТЭЗҮ, зураг төсвийн гүйцэтгэлийн санхүүжилтийн мэдээллийг гаргаж сар бүр Сангийн яаманд хүргүүлэх. | газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам"-ын 5.4.7-д заасны дагуу тус яамны захиалгаар улсын төсвийн хөрөнгөөр 2025 онд хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, санхүүжилтийн сар бүрийн мэдээг Санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэн ажилласан бөгөөд хамгийн сүүлийн сарын гүйцэтгэлийн мэдээнд тусгагдсанаар Барилга байгууламжийн (шилжих барилга болон концессын төслүүд) 33.5 орчим тэрбум төгрөг, тоног төхөөрөмжийн 4.9 орчим тэрбум төгрөг, ТЭЗҮ төслүүдийн 22 орчим тэрбум төгрөгийн санхүүжилтийн олгосон байна. | 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | |
| 6 | Цаг үеийн шинжтэй шуурхай үүрэг даалгаврыг хугацаанд нь биелүүлэх | Хэрэгжилтийн явц, хувиар | - | Хуулийн хугацаанд шуурхай биелүүлсэн байна/ 100 хувь/ | 1. Японы Олон Улсын хамтын ажиллагааны агентлаг (ЖАЙКА)-аас зохион байгуулсан " Enhancement of Startup Ecosystem in Metropolitan | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Area" сэдэвт сургалтад бүх газар нэгжүүдээс санал авч Эдийн засаг, хөгжлийн яамны нэг албан хаагчийн холбогдох материалыг бүрдүүлэн хамруулсан. 2. Удирдлагын Академийн сургалт, судалгааны ажлын төлөвлөгөөнд тусгагдсан сургалтуудад суралцуулах албан хаагчдыг тодорхойлохоор ажиллаж буйтай холбогдуулан тус байгууллагаас Эдийн засаг, хөгжлийн яамнаас хамрагдсан төгсөгчдийн мэдээллийг авч яамны квотод сурсан боловч төгсөөгүй сурагчдад холбогдох мэдээллийг хүргүүлж, сурч төгсөхийг мэдэгдсэн. 3. Эдийн засаг, хөгжлийн яам болон тус байгууллагын дэргэдэх Ахмадын хороо нь ахмадын хорооны гишүүдэд хууль тогтоомжийн дагуу дэмжлэг, тусламж, үйлчилгээ үзүүлэх, тэдний дунд зохион байгуулах үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулах зорилгоор "Хамтран ажиллах гэрээ"-ний төслийг боловсруулан, талуудаар | 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | баталгаажуулсан. 4. Сайдын 2025 оны А/19 дүгээр тушаалаар Худалдааны тухай (Анхдагч хууль) хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэгт гишүүнээр оролцож, хуулийн төслийг олон нийтэд танилцуулах ажлыг зохион байгуулахаар гүйцэтгэгчийг холбогдох хуулийн дагуушалгаруулж, шалгарсан этгээдтэй гэрээ байгуулсан. 5. Сайдын 2025 оны А/18 дугээр тушаалаар байгуулагдсан "Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруула"х чиг үүрэг бүхий ажлын хэсгийн нарийн бичгийн даргаар ажиллаж, удирдлагуудаас өгсөн чиглэл, саналын дагуу хуулийн төсөл болон хуулийн төслийн үзэл баримтлал, товч болон дэлгэрэнгүй танилцуулгыг боловсруулан бүх сайд нараас санал авсан. Мөн хүчин төгөлдөр үйлчилж буй хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ болон төслийн зардлын тооцооны судалгааны | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | тайлангуудыг боловсруулсан. 6. Үндэсний аудитын газраас өгсөн зөвлөмжийн дагуу яамны гэрээний загварууд, гэрээ дүгнэсэн акт, гэрээний зүйлийн задаргаа, хуваарийн загварыг боловсруулсан. | | |
| 3.1. Салбарын бодлого, хөтөлбөр, стратегийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг төлөвлөх, санхүү, хөрөнгийн удирдлага, зохицуулалт, төсөв, санхүүгийн мэдээллээр хангах, шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх, батлагдсан хөрөнгө оруулалтын болон урсгал зардлыг санхүүжүүлэх, гүйцэтгэлийг хянах, үр дүнг тайлагнах; | | | | | | | |
| 7 | ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх. | Тогтоосон хугацаанд үнэн зөв боловсруулах | - | 2025 онд ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлтийг хагас жилээр хугацаанд нь боловсруулсан байна. | Төрийн албан хаагчийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний төслийг боловсруулж батлуулсан/2025.01.15, 2025.03.25, 2025.10.06/. Тус батлуулсан төлөвлөгөөний биелэлтийг хангаж, гүйцэтгэлийг тухай бүр тайлагнан ажиллаж байна. | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |
| 8 | Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс | Хууль тогтоомжид заасан нийтлэг үүргийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллах. | - | Хууль тогтоомжид заасан нийтлэг үүргийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажилласан байна. | 1. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасны дагуу 2025.02.07, 2025.04.03-ны өдрүүдэд ХАСХОМ, 2025.02.07, 2025.10.30-ны өдрүүдэд ХАСУМ тус тус мэдүүлэн, баталгаажуулсан. 2. | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх | | | | Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд заасны дагуу 2023, 2024, 2025 оны хөрөнгө оруулалтын төсөл хөтөлбөрүүдэд хамаарах үндсэн болон нэмэлт гэрээ, хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийг баталгаажуулан санхүүжүүлэхэд холбогдох материалуудыг тухай бүр архивлан, архивын ботыг бүрдүүлэн ажилласан. 3. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд заасанчлан өөрт цохогдож ирсэн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэж 2025 оны байдлаар Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн | | |

182

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | гаргасан хууль тогтоомжийг бүрэн хэрэгжүүлж ажилласан. | | |

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

| № | Үүрэг даалгавар | Өгсөн субьект | Биелэлт |
|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 |

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт | Эхэлсэн, дууссан хугаца | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх | | | | | | | |
| 1 | Өөрийн хариуцсан ажил, мэргэжлийн хүрээнд мэдлэг мэргэжлээ дээшлүүлсэн байх | Сургалтад хамрагдсан байх | - | Сургалтад хамрагдсан байх | 1. Удирдлагын академийн "Ухаалаг төхөөрөмж" сэдэвт цахим сургалтад сууж орчин үеийн ухаалаг төхөөрөмжүүдийг хэрхэн үр дүнтэй ашиглах талаар суралцсан. 2. Удирдлагын академийн "Нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэх нь" сэдэвт цахим сургалтад сууж нийгмийн эгэх хариуцлагын үндсэн ойлголт болон сайн туршлагуудын талаар судалсан. 3. Удирдлагын академийн "ERP систем" сэдэвт цахим сургалтад сууж тус системийн бүрэлдэхүүн, ашиглалтын давуу талын талаар судалсан. 4. АНУ-ын Худалдааны яамны Эрхзүйн арилжааны хөтөлбөртэй хамтран дэд бүтцийн төслийн гэрээний эрхзүйн чиглэлээр чадавх сайжруулах зорилгоор яамнуудын хуульчдад сургалт хамтран зохион байгуулахаар ажилласан бөгөөд тус | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | сургалтын хүрээн дэх түншлэлийн хүрээн дэх онлайн хичээлүүдийг үзэж судалсан. 5. Монголын Хуульчдын холбооны "Хуулийн төсөл боловсруулагчийн сургалт"-д хамрагдаж №ХБ25-07 дугаар гэрчилгээ авсан. 6. Монголын Хуульчдын холбооны хуульчийн мэргэшлийн шалгалтад бэлтгэх 7 хоногийн сургалтад хамрагдаж, Хуульчийн мэргэжлийн шалгалтад тэнцэж хуульч болсон. 7. "Think Pro" ХХК-ийн Excel болон Power BI хэрэглээний программын ахисан түвшний сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан | | |
| 2 | Хариуцсан ажлын хүрээнд хэлэлцүүлэг, семинар, уулзалт, мэдээллийн цагт оролцсон байх | Сургалтад хамрагдсан байх | - | Сургалтад хамрагдсан байх | 1. Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын газраас явуулсан гамшгаас хамгаалах онолын, практик болон тактикийн сургалтуудад 2025.01.31-ны өдөр хамрагдсан. 2. Монгол Улсын Ёс зүйн хорооны Соён гэгээрүүлэх хэлтсийн дарга Ц.Заяхүү, референт З.Соёлмаа нар Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн талаарх сургалтад 2025.03.27-ны өдөр хамрагдсан. 3. Хяналт шинжилгээ, үнэлгээний газраас зохион байгуулж буй энэ удаагийн мэдээллийн цагаар Зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээний тухай сэдэвт мэдээллийн цагт 2025.04.18-ны өдөр хамрагдсан. 4. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн Дэд захирал, Доктор(Ph.D) Н.Алтанзул “Ажил, амьдралын тэнцвэр” сэдэвт сургалтад 2025.04.25-ны өдөр хамрагдсан. 5.Хууль зүй, дотоод хэргийн яамнаас Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийн хэлэлцүүлэгт 2025.05.12-ны өдөр оролцсон. 6. Эдийн | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | засгийн хөгжлийн төв болон Тони Блэйрийн Институттэй хамтран зохион байгуулсан "Хөрөнгө оруулалтын үр нөлөөтэй хэрэгжилт ба уялдаа холбоо" сэдэвт сургалт, семинарт Эдийн засаг, хөгжлийн яамыг төлөөлөн оролцож, хамрагдсан. 7. Хууль зүй, дотоод хэргийн яамнаас Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх тухай анхдагч хуулийн төслийн хэлэлцүүлэгт 2025.01.10-ны өдөр оролцсон. 8. Эдийн засаг, хөгжлийн яамнаас 2025.03.13-ны өдөр зохион байгуулсан "Төр, хувийн хэвшлийн түншлэлийн форум"-д оролцсон. 9. "Мал эмнэлгийн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн чадавх, судалгааны үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэх боломж" сэдвээр Мал эмнэлгийн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн захирал, Профессор Бадгарын Батцэцэгийн мэдээллийн цагт 2025.11.07-ны өдөр хамрагдсан. | | |

ХЯНАСАН:

ТЗУГ-ийн Санхүүгийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Жаргалсайхан Гэрэлбат /............................................/

Огноо: 2025.12.15

ТАЙЛАН ГАРГАСАН:

ТЗУГ-ийн Санхүүгийн хэлтсийн Хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн, Бадамдорж Баасансүрэн /............................................/

Огноо: 2025.12.15